



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэрэн сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2025/07/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Дундговь аймаг

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ

Утас: 70592225

Цахим хаяг: [oyun-erdenet@audit.gov.mn](mailto:oyun-erdenet@audit.gov.mn)

Ахлах аудитор: Т.Батсайхан

Утас: 70593113

Цахим хаяг: [batsaikhant@audit.gov.mn](mailto:batsaikhant@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
5. Аудитын илрүүлэлт .....	8
<b>5.1.1 Албан шаардлага</b> .....	8
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	10

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

᠒᠐25.03.25 № 85

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ДЭРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Д.ЖАМБАЛПРАГЧАА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 323,994.9 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн татварын орлого 140.8 хувиар биелсэн, хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгоогүйтэй тус тус холбоотой байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

#### Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

#### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 хөтөлбөр, 8 зорилт, 62 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 85.6 хувийн гүйцэтгэлтэй

4825020292

тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн болно.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>808,352.8</b>	<b>1,147,364.2</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	400,504.8	724,499.7
33	АВЛАГА	163,375.0	164,218.1
34	УРЬДЧИЛГАА	-	55.0
35	БАРАА МАТЕРИАЛ	234,472.9	240,091.4
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10,000.0	18,500.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>866,807.2</b>	<b>1,200,120.0</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	866,807.2	1,200,120.0
39200	Биет хөрөнгө	857,990.0	1,192,621.6
39300	Биет бус хөрөнгө	8,817.2	7,498.4
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,675,160.0</b>	<b>2,347,484.2</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,120.6</b>	<b>14,625.8</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,120.6	14,625.8
41300	Өглөг	3,120.6	14,625.8
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,672,039.5</b>	<b>2,332,858.4</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,672,039.5	2,332,858.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	415,427.2	415,427.2
51200	Хуримтлагдсан үр дүн	1,157,208.4	1,818,027.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	99,404.0	99,404.0
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,675,160.0</b>	<b>2,347,484.2</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,384,760.2</b>	<b>2,447,563.5</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>321,167.2</b>	<b>639,677.2</b>
110	Орлогын албан татвар	152,119.0	378,084.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	152,119.0	378,084.3
113	Хөрөнгийн албан татвар	99,095.9	52,266.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	69,952.3	209,326.3
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>271,800.8</b>	<b>643,954.4</b>
120	Нийтлэг татварын бус орлого	271,800.8	643,954.4
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>791,792.2</b>	<b>1,163,931.9</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>945,403.0</b>	<b>1,399,146.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>945,403.0</b>	<b>1,399,146.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>916,052.7</b>	<b>1,342,116.0</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	332,946.2	521,375.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,328.4	64,549.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,418.9	254,604.3
2104	Хангамж, бараа материалын зардал	74,537.3	77,074.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47.4	49,934.1
2107	Томилолт, зочны зардал	13,520.0	20,154.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	233,947.0	20,327.3

Дундговь аймгийн Дэрэн сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	204,307.4	334,097.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,350.3	57,030.1
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>439,357.1</b>	<b>1,048,417.4</b>
V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>478,539.2</b>	<b>387,598.5</b>
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(39,182.0)</b>	<b>660,819.0</b>

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,715,815.5	1,715,815.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(4,594.0)	(4,594.0)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,711,221.5	1,711,221.5
9	Тайлант үеийн үр дүн	(39,182.0)	(39,182.0)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,672,039.5	1,672,039.5
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,672,039.5	1,672,039.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,672,039.5	1,672,039.5
19	Тайлант үеийн үр дүн	660,819.0	660,819.0
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,332,858.4	2,332,858.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,249,871.7</b>	<b>1,938,768.9</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>321,167.2</b>	<b>639,677.2</b>
110	Орлогын албан татвар	152,119.0	378,084.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	152,119.0	378,084.3
113	Хөрөнгийн албан татвар	99,095.9	52,266.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	69,952.3	209,326.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,142.0	19,557.5
1181	Газрын төлбөр	19,975.3	19,728.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	41,835.0	170,040.0
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>136,912.3</b>	<b>135,159.8</b>
120	Нийтлэг татварын бус орлого	136,912.3	135,159.8
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>791,792.2</b>	<b>1,163,931.9</b>
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>817,295.0</b>	<b>1,272,380.3</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>817,295.0</b>	<b>1,272,380.3</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>787,944.8</b>	<b>1,215,350.3</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	334,686.3	515,435.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,328.4	64,549.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,418.9	254,659.3
2104	Хангамж, бараа материалын зардал	37,017.2	51,524.9
2105	Нормативт зардал	645.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,814.5	44,003.3
2107	Томилолт, зочны зардал	13,520.0	19,814.0

Дундговь аймгийн Дэрэн сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	234,217.4	20,327.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,296.9	245,036.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,350.3	57,030.1
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>432,576.6</b>	<b>666,388.6</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>504,714.3</b>	<b>342,393.7</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	504,714.3	342,393.7
2200	Дотоод эх үүсвэрээр	504,714.3	342,393.7
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(504,714.3)</b>	<b>(342,393.7)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(106,000.0)</b>	<b>-</b>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	106,000.0	-
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(178,137.6)</b>	<b>323,994.8</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	578,642.4	400,504.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	400,504.8	724,499.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,023,776.4</b>	<b>1,531,970.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,466,218.3</b>	<b>1,200,576.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,415,866.9</b>	<b>1,150,718.7</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	556,361.1	515,435.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,032.8	64,549.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	279,333.0	253,659.3
2104	Хангамж, бараа материалын зардал	39,269.2	30,911.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,587.1	44,003.3
2107	Томилолт, зочны зардал	20,070.4	19,814.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,925.7	2,996.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	391,287.6	219,350.4
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>50,351.4</b>	<b>49,857.9</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,351.4	49,857.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	413,202.1	331,393.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	144,356.0	-
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,023,776.4</b>	<b>1,614,663.2</b>
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	310,997.8	298,557.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,303,335.1	1,197,480.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	409,443.5	118,624.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	333,517.6
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	416,229.1

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>75,557.7</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>75,557.7</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>68,385.5</b>
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	20,613.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,331.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,440.3
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,172.2</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,950.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,222.2
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>75,557.7</b>
131101	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,557.7

## 5. Аудитын илрүүлэлт

### 5.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй. Харин мал хамгаалах сангийн санхүүгийн тайлангийн аудитаар **30,000.0** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илрүүлж **30,000.0** мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

*Залруулагдаагүй алдаа:*

Аудитаар **30,000.0** мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илрүүлж **30,000.0** мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

#### 5.1.1 Албан шаардлага

1. Аудитаар сангийн хөрөнгөөр хийгдсэн **30,000.0** мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “**Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх**” бараа үйлчилгээг тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийж, нийт төсөвт өртгийг хуваан нэг компанитай шууд худалдан авах гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах /ТБОНӨХБАҮХА/ тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д /Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно/, 8 дугаар зүйлийн 8.6-д /Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно./, 8.7.1.-д /тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох;/ заасныг тус тус зөрчсөн байна.

### 5.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дундговь аймгийн Дэрэн сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	Засаг даргын Тамгын газар	1	1				1		
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	<b>НИЙТ</b>	6	1	5			1		

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 25,939.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 5,939.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 20,000.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ. Үүнээс аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 77.1 хувийг залруулагдаагүй, 22.9 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Төсөвт байгууллагуудын 2024 санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар хүргүүлсэн 20,000.0 мянган төгрөгийн 2 албан шаардлагын хариуг ирүүлээгүй байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 20,000.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшингээс 14.3 хувиар бага байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:**

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Засаг даргын Тамгын газар	1	5,939.9			1	5,939.9	1	5,939.9				
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>5,939.9</b>			<b>1</b>	<b>5,939.9</b>	<b>1</b>	<b>5,939.9</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :**

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс:									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засаг даргын Тамгын газар	1	20,000.0	-		1	20,000.00						
2	Орон нутгийн хөгжлийн сан	1	-	-	-	1	-						
	<b>Нийт зөрчлийн дүн</b>	<b>2</b>	<b>20,000.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>20,000.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:**

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>			<b>-</b>	<b>-</b>		
2. Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тусгай зориулалтын сан	1	30,000.00			1	30,000.00		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>30,000.0</b>			<b>1</b>	<b>30,000.0</b>		
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>30,000.0</b>			<b>1</b>	<b>30,000.0</b>		